

## **ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Өсвөр насны хүүхэд, залууст цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгох зорилгоор "ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЗӨВ ХЭРЭГЛЭЭ" сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарласан.

### **“ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЗӨВ ХЭРЭГЛЭЭ” СЭДЭВТ ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ ШАГНАЛЫГ ГАРДУУЛЛАА**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ГХУСАЗСЗ-өөс өсвөр насны хүүхэд залууст цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгохоор зорилгоор “Цахим орчин дахь зөв хэрэглээ” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарласан ба тус уралдаанд нийт 46 сурагчид эссэ ирүүлсэн байна.

Сонгох шалгаруулах ажлыг Ерөнхий боловсролын сургуулийн багш болон аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ-ийн гишүүдээс бүрдсэн баг шалгаруулах журмын дагуу шалгаруулсан юм.

Тэргүүн байранд 1 дүгээр сургуулийн 11в ангийн сурагч С.Цолмон /40 оноогоор/  
Дэд байранд Хан-Уул цогцолбор сургуулийн 11б ангийн сурагч Б.Одонцацрал /38 оноогоор/

Гутгаар байранд Хан-Уул цогцолбор сургуулийн 10а ангийн сурагч Э.Чинхүслэн /37 оноогоор/  
Тусгай байранд 8 дугаар сургуулийн 10а ангийн сурагч Б.Мөнхбагана /36 оноогоор/ нар шалгарлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, ГХУСАЗСЗ-ийн дарга Л.Хишигтогтох баяр хүргэж шагналыг гардуулав.

### **“ТРОЛЛЫГ ТОРЛОЁ” АЯНГ ӨНӨӨДРӨӨС ЭХЛҮҮЛЛЭЭ.**

Өнөөдөр сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэллээ. Үүнийг дагаад нэр нүүрээ нуусан хуурамч ТРОЛЛ хаягнууд борооны дараах мөөг шиг л нэмэгдэж байна.

Аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ цахимаар бусдыг гүтгэх доромжлох, хуурч залилах, садар самуунд уруу татах, худал хуурмаг мэдээлэл түгээх болон хүүхдийн хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлөх зэрэг зүй бус явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Цахим орчинг зөв болгое уриатайгаар “ТРОЛЛЫГ ТОРЛОЁ” аянг эхлүүлсэн.

**"АРХИГҮЙ ИРЭЭДҮЙ ГОЁ"** аяны хүрээнд "АРХИГҮЙ ИРЭЭДҮЙГ БИД БҮТЭЭНЭ" масктай уулзалтыг зохион байгууллаа

Тус уулзалтын зочноор Архидалтын эсрэг Оюуны есөн дэвшил ТТБ-ын Тэргүүн Н.Хүрэлбаатар оролцож өөрийн амьдралын түүх, архины хор уршиг, байгуулагынхаа хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар илэн далангүй ярилцлаа.

### **"ШИНЭ ТЕХНОЛОГИЙН" БОЛОН "НОГООН ТЕХНОЛОГИЙН" ЧИГЛЭЛИЙН ТӨСЛҮҮДИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮН ГАРЛАА**

Орон нутагт шинэ технологи болон ногоон технологийг нэвтрүүлж, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор Үндэсний хөгжлийн газар болон Германы GIZ, ЭТИС хөтөлбөр, аймгийн ИТХ-ын дэргэдэх "Тогтвортой хөгжил - Түншлэл" зөвлөл хамтран "Шинэ технологийн" болон "Ногоон технологийн" чиглэлийн төслүүдийг 2020 оны 01 дүгээр 15-наас 03 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хүлээн авч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан дүнгээ гаргажээ.

Дорнод аймгаас Д.Ганзориг захиралтай "Онхоодой" ХХК, Б.Алхбаатар захиралтай "Учрал хийц" ХХК, Б.Гарьд захиралтай "Дорнын оргил" ХХК-ий төсөл шалгаран 30 хүртэл сая төгрөгийн тоног төхөөрөмжийг буцалтгүйгээр дэмжлэг авахаар боллоо.

### **АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ "ШИЛЭН ДАНС - ИРГЭДИЙН ХЯНАЛТ" АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЭХЭЛЛЭЭ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Дорнод аймгийн Санхүүчдийн Холбоотой хамтран аймаг, сумын түвшинд Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулж байгаа эсэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсын мэдээллийг ашиглан иргэдэд хяналт үнэлгээ шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

Шилэн дансны тухай хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхэд оршино.

Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсын мэдээллийг ашиглан иргэдэд хяналт үнэлгээ шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан Т.Гантулга, Дорнод аймгийн Санхүүчдийн холбооны Тэргүүн Д.Отгонбадрах, аймгийн Санхүү хяналт, аудитын албаны дарга Б.Саранчимэг нар уулзаж тус ажлын хүрээнд хийгдэх хяналт мэдээллийн ажлын талаар санал бодлоо солилцов.

### **ДОРНОД АЙМАГТ ҮЙЛДВЭРЛЭЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ КАТАЛОГИ СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЖ БАЙНА**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд "Төр, хувийн хэвшлийн зөвлөл" ажилладаг ба тус зөвлөл нь хувийн хэвшлийн тулгамдсан асуудлуудыг

төрийн бодлого шийдвэрт тусгуулан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах зорилготой юм

Тус зөвлөлийн ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтаар Дорнод аймагт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг таниулах, байр сууриа олох, үнэнч хэрэглэгчдийг бий болгох зорилготой вэб-д суурилсан каталоги систем хийгдэж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, “Төр, хувийн хэвшлийн зөвлөл”-ийн дарга Л.Хишигтогтох вэб-д суурилсан каталоги системийг хөгжүүлж буй компанийн төлөөлөлтэй уулзаж санал бодлоо солилцов.

### **Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган Монгол Улсын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2020 оны эхний хагас жилийн байдлаар 91.1 хувь, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2020 оны эхний хагас жилийн байдлаар 68.2 хувийн дундаж үнэлгээтэй тус тус үнэлэгдэж, тайлангийн дүгнэлтийг аймгийн Засаг даргын 2020 оны 15 дугаар Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн цахим сан [new.unelgee.gov.mn](http://new.unelgee.gov.mn) сайтад байршууллаа.

Мөн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монголын чанарын удирдлагын зөвлөхүүдийн холбооноос зохион байгуулсан “Чанарын удирдлагын тогтолцоо ба дотоод аудит” сэдэвт 8 цагийн сургалт, Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ цахим сургалтад хэлтсийн дарга, 2 мэргэжилтний хамт хамрагдсан

### **ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:**

Орон нутгийн нийторлого 47749.4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 45946.1 сая төгрөг, үүнээс татварын орлого 9465.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 10008.1 сая төгрөгт хүрч 542.7 сая төгрөгөөр давж, татварын бус орлого 38284.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 35938.0 сая төгрөгт хүрч 2346.1 сая төгрөгөөр тасарлаа.

### **Орон нутгийн төсвийн нийт орлого**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	47,749,441,500.00	45,946,087,180.00	(1,803,354,320.00)	96.22

003	ТАТВАРЫН ОРЛОГО	9,465,303,700.00	10,008,062,785.60	542,759,085.60	105.73
004	Орлогын албан татвар	5,505,027,500.00	6,593,457,721.65	1,088,430,221.65	119.77
016	Хөрөнгийн албан татвар	682,091,200.00	677,069,699.40	(5,021,500.60)	99.26
021	Бусад татвар, төлбөр, хураамж	3,278,185,000.00	2,737,535,364.55	(540,649,635.45)	83.51
041	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,284,137,800.00	35,938,024,394.40	(2,346,113,405.60)	93.87
042	Нийтлэг татварын бус орлого	2,106,059,500.00	1,822,926,789.40	(283,132,710.60)	86.56
049	Хөрөнгийн орлого	0.00	29,648,760.00	29,648,760.00	
056	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	27,885,635,900.00	26,855,125,045.00	(1,030,510,855.00)	96.3
058	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	24,577,674,300.00	24,577,674,300.00	-	100.0
059	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	3,307,961,600.00	2,277,450,745.00	(1,030,510,855.00)	68.8

#### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 50703.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 38493.2 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 4219.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 24577.6 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

#### Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
----------	---------------------------	---------------------------	-------	------

НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,703,120,400.00	38,493,163,757.75	(12,209,956,642.25)	75.9
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	23,296,774,100.00	19,987,490,877.26	(3,309,283,222.74)	85.8
Ажиллогчоснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	3,040,898,700.00	2,510,540,798.94	(530,357,901.06)	82.6
Бараа үйлчилгээний бусад зардал	3,107,354,000.00	1,889,483,402.15	(1,217,870,597.85)	60.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,508,109,300.00	1,041,732,673.89	(466,376,626.11)	69.1
Б. ХӨРСНГИЙНЗАРДАЛ	9,993,677,700.00	5,545,898,733.90	(4,447,778,966.10)	55.5

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, [www.dornod.gov.mn](http://www.dornod.gov.mn) вэб сайт, 70583034, 70582372 дугаарын утсаар авч болно

## **Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, аймгийн Засаг даргын 270 захирамжид виз өгч, 7 сумын Засаг даргын 572 захирамж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 31 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх” журам нь хуулиар эрх олгогдоогүй асуудлаар гаргасан шийдвэр байх хүчингүй болгох чиглэлийг хүргүүлсэн.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 13 өргөдөл ирүүлснээс 11 өргөдөл гомдлыг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч ажилласан. аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүссэн 1 иргэнд 500.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол улсын Засгийн газрын 2010 оны 316 дугаар тогтоолоор батлуулсан Магнай трейд ХХК нь Дорнод аймгийн нутаг дэвсгэрт байрлах Баянтүмэн 17 дугаар талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагааг 2018 оноос эрх бүхий албан тушаалтан болох аймаг, сумын Засаг даргаас холбогдох хууль тогтоомжийн дагуу авах ёстой зөвшөөрлийг авалгүйгээр газар түүний хэвлийг дур мэдэн ашиглаж зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр өрөмдлөгийн цамхаг бусад техник хэрэгсэл, ажилчдын байрлах байр буюу кемпийг байрлуулан Монгол улсын Газрын тухай хууль болон Барилгын тухай хууль, бусад хууль тогтоомжийг зөрчсөн тул хууль бусаар ашиглаж буй газрыг чөлөөлөхийг Магнай трейд ХХК-д даалгасан аймгийн Засаг даргын 2019 оны А/626, 2020 оны А/280 захирамжийг хүчингүй болгуулахаар тус компаниас Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандсантай холбогдуулан тус хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүх хурал 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдөр болж нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож аймгийн Засаг даргын дээрх шийдвэрүүдийг хэвээр үлдээсэн.

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Зүүн бүсийн тулгуур төв-Чойбалсан хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй 5,5 км хатуу хучилттай авто зам, дугуйн зам барих ажлын транст давхцал үүсгэсэн Магнай трейд ХХК шатахуун түгээс станцын зориулалт бүхий газрыг чөлөөлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан.

## **Архивын чиглэлээр:**

Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат /2017-2020/-нд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **1. Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:**

Архивын тасагт 2020 оны 6 дугаар сарын 30-ний байдлаар ирсэн 8 албан бичгийг авч бүртгэн, гадагш 3 тодорхойлолт, 8 албан бичиг боловсруулж явуулсан байна. 3 хариутай бичгийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

### **2. Баримт ашиглалтын талаар:**

6 дугаар сард 75 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 256 хуулбар, 8 тодорхойлолт, 35 иргэнд 135 оны малын А данс гаргаж нийт 1 433 000 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 52 хөмрөгийн 186 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав.

2020 ий 6 дугаар сарын 1-ны өдрөөс 30-ны өдөр 850 хөмрөг, 14 850 хөмрөгийн 186 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав.

Шинээр 3 байгууллагын материалыг хүлээн авч эх хувийг бэлтгэн стандартын дагуу хэвлэж өгөв.

### **3. Цахим хэлбэрт оруулсан баримтын талаар:**

2020 онд цахимжуулах төлөвлөгөөг боловсруулж, сар, улирал, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

- Цахим холболт- 67 хадгаламжийн нэгжийн 10592 хуудас баримт
- Хүний нэр-45066
- Агуулга-9404
- Байгууллагын нэр-0
- Газар зүйн нэр-0

Мөн хөмрөг 92 буюу Нэгдсэн эмнэлэгийн 1985-1988 оны 5 хадгаламжийн нэгжийн 789 хуудасыг фотошопдож, PTF файл үүсгэн ажиллаа.

## **4. Зөвлөгөө**

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэл төв, Хөлөнбуйр сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудад заавар зөвлөгөө өгөв.

## **5.Баримтын нөхөн бүрдүүлэлт**

6 дугаар сард Хөлөнбуйр сумын ЗДТГ-ын 1952-2012 оны цаасан суурьтай 156 ХН,цахим тээгч бүхий 102 CD-г бүртгэлийн хамт хүлээн авлаа. Мөн Улсын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн саналын хуудас 33 хайрцаг хүлээн аваад байна.

## **6.Бусад**

Барилга байгууламж хүлээн авах 11 удаагийн улсын комиссын бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж заавар, зөвлөгөө өгөв.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран бусад аймаг, хотуудад тэтгэвэр тогтоолгосон 30 иргэний хувийн хэрэгт хавсаргагдсан хуулбар лавлагаа, эх баримттай тулгалт хийв.

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 6 дугаар сарын 2, 9-ний өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 6 дугаар сарын 12,19,26-ны өдрүүдэд хөтөлж ажиллаа.

## **Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

### **Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**

### **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

#### **ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**


**Бод малын зохиомол хээлтүүлгийн “Мал үржүүлгийн технологи” бэлтгэх сургалтанд иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан тухай:** “Малын удмын сангийн үндэсний төв”, Нийслэлийн хөдөө аж ахуйн газар, “Нутаг академи” ТТБ, Бэлчээрийн менежмент төслийн нэгж хамтран бод малын зохиомол хээлтүүлгийн мэдлэг, арга зүй эзэмшүүлэх онол, дадлага хослуулан “Мал үржүүлгийн технологич” бэлтгэх 10 хоногийн сургалтад Дорнод аймгийн Хэрлэн сумаас 1, Гурванзагал сумаас 1, нийт 2 сумын мэргэжилтэн хамрагдсан.



**Бэлчээрийн үлийн цагаан огтоно устгасан талаар:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/89 дугаар тушаал, Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/219 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной 7 сумын нутаг дэвсгэрт зохион байгуулж 564 малчид, ажилгүй иргэд, 311 машин техник оролцож, шувууны үүр, суудал 2740 ширхэгийг суулгаж 27160 га талбайд байрлуулсан. Утах аргаар 13650 га газарт, ус цутгах аргаар 16040 га газарт, 973 ширхэг хавх тавих, конус цилиндр, үлий цооноглох аргаар 45420га , үлийтэй 8200 га газарт тэмцэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. Аймгийн мэргэжлийн хяналтын ургамал, хорио цээрийн хяналтын улсын байцаагчын дүгнэлтээр аймгийн бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг 2020 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 12-02-021/75 тоот актаар хүлээн авч аймгийн хэмжээнд 81,0 хувьтай дүгнэсэн байна.

### Отрын нөөц бэлчээрийн судалгаа хийх:

Аймгийн хэмжээнд 10 сумын 1,6 сая га бэлчээрийг сумын ИТХ-ийн шийдвэрээр нөөц бэлчээр болгон авсан байна. Тус нөөц бэлчээрт авсан газрын байршлууд нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газар, Орон нутгийн тусгай хэрэгцээний газар, Улсын тусгай хамгаалалттай газартай давхцаж байна.



Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны сайдын А-153 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг сум дундын отрын нөөц бэлчээрийн судалгаа хийх, отрын бэлчээрийн хилийн заагийг баталгаажуулах газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах ажлаар Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Бэлчээр ашиглалт хариуцсан мэргэжилтэн Н.Бямбадоржоор ахлуулсан ажлын хэсэг , аймгийн ХХААГ, ГХБХБГазрууд хамтран Матад суманд ажиллаж сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар, холбогдох мэргэжилтэнүүдтэй санал солилцож 2 байршилд 79,8 га газрыг отрын нөөц бэлчээрт авах урьдчилсан санал орууллаа.

Сум дундын отрын нөөц бэлчээр байгуулж, Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2020 оны А/369 дугаар захирамжаар байгуулан ажиллаж байна.

**Малын зохимол хээлтүүлгийн талаар:** Малын үүлдэр угсаа сайжруулах зорилгоор Хөлөнбуйр сумын Баян-Өлзийт 1 дүгээр багийн 1 малчны 30 үнээнд махны чиглэлийн ангус үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлгийг Улаанбаатар хотын мал зүйч А.Давгадорж хийсэн.

### ГАЗАР ТАРИАЛАН ЧИГЛЭЛЭЭР:

Энэ онд аймгийн хэмжээнд ХХААХҮ-ийн сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 22.6 мянган га-д үр тариа, үүнээс 18.5 мянган га-д улаан буудай, 4.5 мянган га-д тосны ургамал, 2.5 мянган га-д малын тэжээл 161 га-д төмс, 117 га-д хүнсний ногоо тариалж, үр тарианы ургац 27.0 мянган тн, үүнээс 22,2 мянган тн улаан буудай, 4.8 мянган тн бусад үр тариа, 3.6 мянган тн тосны ургамал, 1.9 мянган тн төмс, 1.4 мянган тн хүнсний ногооны ургац хураан авахаар төлөвлөөд байна. Нийт 93.2 мянган га эргэлтийн талбайн 35.0 мянган га-д тариалалт, 35.2 мянган га-д уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөж 70.2 мянган га буюу 75.4 хувь эргэлтэд оруулаад байна.

Нийт эргэлтийн талбай (га-аар)	Тариалсан талбай (га-аар)	Боловсруулах уриншийн захиалга (га-аар)	Эргэлтэнд орох талбай (га-аар)	Талбайн Ашиглалт ( хувиар)
<b>93266</b>	<b>35083</b>	<b>35280</b>	<b>70363</b>	<b>75.4</b>

2020 оны 06 сарын 25-ны байдлаар 35.0 мянган га-д тариалалт хийгдэж үүний 61 хувь нь улаан буудайн тариалалт эзэлж нийт тариалалтын төлөвлөгөөг 17.4 хувиар давуулан биелүүлээд байна.

ДОРНОД АЙМГИЙН ТАРИАЛАЛТЫН МЭДЭЭ	2020 оны төлөвлөгөө	Нийт үр тариа (га-аар)	Тарьмлын төрлөөр								Нийт тариалах талбай (га-аар)
			Үр тариа таримлын төрлөөр (га-аар)				Бусад тарьмал (га-аар)				
			Буудай	Арвай	Овьёос	Бусад үр тариа	Тосны ургамал	Малын тэжээл	Төмс	Хүнсний ногоо	
Тариалах төлөвлөгөө (га-аар)	22600	18500	300	300	3500	4500	2500	161	117	<b>29878</b>	
Тариалсан талбайн хэмжээ (га-аар)	28127	21411	50	2875	3791	1968	4718	159	111.3	<b>35083</b>	
Төлөвлөлтийн гүйцэтгэл	124.5	115.7	16.7	958	108.3	43.7	188.7	98.5	95.1	<b>117.4</b>	
Тариалсан талбайд тарьмлын эзлэх хувь	80.2	61.0	0.1	8.2	10.8	5.6	13.4	0.5	0.3	<b>100</b>	

**Тариалалтын хувь:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 07 дугаар хуралдааны 09 тогтоолоор батлагдсан Таримлыг тариалангийн талбайн сэлгээнд тариалах тухай тогтоолын хүрээнд нийт тариалсан талбайн 80.2 хувьд үр тариа, үүний 61 хувьд улаан буудай, 5.6 хувьд тосны ургамал, 13.4 хувьд малын тэжээл, 0.8 хувь төмс, хүнсний ногоо тус тус эзэлж байна.

### **ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**Хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгаа:** Хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэр, худалдаан дахь үлдэгдлийн судалгаа, нөөцийн мэдээг 14 сумаас авч нэгтгэн 7 хоног бүрийн баасан гарагт ХХААХҮЯ-нд болон аймгийн Онцгой комисст хүргүүлэн ажиллаж байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоол бусад холбогдох хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, стандартын шаардлага хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид давтан зөрчил гаргуулахгүй байлгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 2020 оны 6 дугаар сарын 23-наас 6 дугаар сарын 26-ны өдрүүдэд тохирлын үнэлгээ хийж ажилласан.

Тохирлын үнэлгээнд нийт 4 хүнсний дэлгүүр, 2 хагас боловсруулсан бүтээгдэхүүн хамруулсан. Үүнд: Хэрлэн сум 1-р баг ажилчин 3-311 тоотод байрлах "МБИЭ" ХХК-ийн хүнсний дэлгүүр, Хэрлэн сумын 1-р баг станцын цэнхэр 51-р байранд байрлах "Хялганатын тал" ХХК-ийн хүнсний дэлгүүр, Хэрлэн сум 1-р баг силикатын 0-03 тоотод байрлах "Дорнын тэгш баяр" ХХК-ийн хүнсний дэлгүүр, Хэрлэн сум 3-р баг дэнжийн 01-22 тоотод байрлах "Олон нуурын өгөөж" ХХК-ийн хүнсний дэлгүүр, Хэрлэн сум 9-р баг 17-03 тоотод байрлах "Стар" хагас боловсруулсан бүтээгдэхүүний цех, Хэрлэн сум 1-р баг цэнхрийн 38 тоотод байрлах "Түшиг мандах нар" ХХК-ийн хагас боловсруулсан бүтээгдэхүүний цех тус тус хамрагдсан.

Худалдаа, үйлдвэрлэлийн газрын тохирлын үнэлгээг хийхдээ Монгол улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтын 6 дугаар схемийн дагуу жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ ерөнхий шаардлага MNS 5021-1:2019, MNS 6421-2013, MNS 5075-2001 стандартын дагуу боловсруулсан үнэлгээний хуудсаар үнэлсэн.

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:** **Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээ:** Монгол улсын Засгийн газрын 2019 оны 362 дугаар тогтоолоор батлагдсан "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын "BEST"

хөтөлбөртэй хамтран “Хоршооны хөгжлийн үнэлгээний арга зүй” сэдэвт сургалтыг 14 сумын мэргэжилтнүүдэд зохион байгуулсан.

Сургалтаар Хоршооны тухай ойлголт, Үнэлгээнээс хүлээгдэж буй үр дүн, үнэлгээний арга зүй, үзүүлэлтүүд, үнэлгээний ажлын үе шатууд ба явц, оноо өгөх ба хөгжлийн төвшинг үнэлэх, анхаарах асуудал зэрэг сэдвээр аймаг, сумын мэргэжилтнүүдэд хоршоодыг үнэлэх аргачлалын талаар арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу нийт 33 төслийг хүлээн авч программ оруулаад байна. Үүнээс журмын 1.4-р заалтаар 6 аж ахуйн нэгжийн төсөл, 5.9-р заалтаар 4 аж ахуйн нэгжийн төсөл хасагдаж, дараагийн шатны шалгаруулалтад 22 аж ахуйн нэгжийн төсөл орохоор болоод байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих зорилго бүхий дэд хороог аймгийн Засаг даргын 2020 оны А/320 дугаар захирамжаар байгуулаад байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх төвийн барилгын засварын ажлын явц 80 хувьтай явагдаж байна.

Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэртэй зээлээс Дорнын сүрвэй ХХК, Вүүд мээд ХХК-ний төслүүдийг Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан зээлийн батлан даалтын санд хүргүүлэн, анхан шатны судалгааг хийж байна.

Дорнын сүрвэй ХХК нь үйлдвэрлэлийн байрын зоорийн давхар, нэг давхрын хэсгийг барьж, санхүүжилтийн шаардлага тулгараад байна.

Арьс, шир түүхий эдийн үнэ ханшийн мэдээг 7 хоног бүрийн пүрэв гарагт гаргаж, ХХААХҮ-ийн Хөнгөн үйлдвэрийн газарт хүргүүлж байна.

#### **МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Мал эмнэлгийн газрын 2020 оны сар, улирал, хагас жилийн мэдээг МЭЕГ-ын даргын баталсан “Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах” журмын хавсралтын дагуу 14 сумын МЭТ-аас мэдээг авч нэгтгэж, газрын даргаар хянан баталгаажуулан, албан тоотын хавсралтаар болон файлаар МЭЕГ-т хүргүүлэн ажилласан.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225, 43 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 01 албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 02 удирдамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/34, 63 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/194, 195,

122 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Дашбалбар суманд хяналт шалгалт хийж ажилласан.

#### **Гоц халдварт болон халдварт өвчний дархлаажуулалтын талаар:**

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2020 оны эхний ээлжийн дархлаажуулалтанд 2,2 сая толгой мал сүрэг хамруулахаас 1,8 сая толгойг хамруулж 90 хувийн гүйцэтгэлтэй дууссан. Орон нутгаас санхүүжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 365,900 толгой мал, амьтан хамрагдахаас 164,655 толгой мал, амьтан хамрагдаж, 45 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. МЭГ-ын даргын А/12 тоот тушаалын дагуу мал, амьтны зооноз халдварт боом өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 290,0 мянган толгой бод, бог малыг хамрагдахаас 244,6 мянган толгой мал хамрагдаж 84,3 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

#### **Оношлогоо, тандалт шинжилгээний талаар:**

Баянтүмэн, Цагаан-Овоо сумдаас онош тогтоох зорилгоор ирүүлсэн дээжинд стандарт арга зүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж гүйцэтгэж Баянтүмэн сумын 2-р багт энтеробактериоз, Цагаан-Овоо сумын 6-р багт сальмонеллез өвчнүүд оношлогдсон.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын дараах тандалтыг Матад, Чойбалсан, Дашбалбар сумдын нийт 45 өрхийн 675 толгой малаас цусны дээж авч ийлдсийг ялган МЭАЦЛ-т шинжилгээг хийж гүйцэтгэж байна. Баянтүмэн сумын 2-р багийн Худаг уул гэх газарт энтеробактериоз, Цагаан-Овоо сумын 6-р багт сальмонеллез халдварт өвчнүүд оношлогдож, сэргийлэх арга хэмжээг зааврын дагуу зохион байгуулан ажилласан.

#### **Газрын харилцааны чиглэлээр:**

Аймгийн хэмжээнд газрын төлбөрийн орлогын 2021 оны төслийг Татварын хэлтэст 2020 оны 1/520 дугаар албан бичгээр хүргүүллээ. Тайлангийн хугацаанд Хөлөнбуйр сум 3 нэгж талбарт 3,09 га, Хэрлэн сум 3 нэгж талбарт 1,164 га, Баянтүмэн сум 3 нэгж талбарт 3,06 га, Матад сум 3 нэгж талбарт 0,35 га Чулуунхороот сум 9 нэгж талбарт 107,39 га газарт тус тус дуудлага худалдааг зохион байгуулсан. Матад, Хөлөнбуйр, Хэрлэн сумдад 6 нэгж талбарт нийт 22.042,4 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн бол Баянтүмэн сумын ялагчийн мөнгө төлөх хугацаа болоогүй байна. Чулуунхороот суманд дуудлага худалдаанд оролцогч байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/563 дугаар захирамжаар байгуулагдсан Газар зүйн нэрийн салбар зөвлөл нь сумдын Засаг даргын захирамжаар байгуулагдсан дэд зөвлөлийн гишүүдтэй 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 14 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд хуралдлаа.

Тус цахим хуралд аймгийн төвийн Хэрлэн сумаас бусад 13 сумд оролцсон бөгөөд Газар зүйн нэрийн хууль эрх зүйн орчин, өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар мэдээ, мэдээллийн солилцсон үр дүнтэй хурал боллоо.

**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

2020 онд улс, орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх засвар үйлчилгээ, тохижилт, авто зам, барилга угсралтын он дамжин хийгдэж буй 18 төсөл арга хэмжээ, энэ жил шинээр гэрээ байгуулсан 88 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 1 болон 5 дугаар сургуулийн бага сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг “ДОЦ” ХХК хийж гүйцэтгэж байна.

Одоогоор 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын ажил 90%-ийн гүйцэтгэлтэй дотор заслын ажил хийгдэж байна. 5 дугаар сургуулийн барилгын ажил 80%-ийн гүйцэтгэлтэй гадна фасад болон дотор агааржуулалтын хоолой угсрах, гадна инженерийн шугам сүлжээний ажил, дотор шавардлага өнгөлгөөний ажил хийгдэж байна.

1-р сургуулийн өргөтгөлийн барилга

5-р сургуулийн өргөтгөлийн барилга

Баянтүмэн сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга болон Хэрлэн сумын 3-р багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг “Талын сүлд” ХХК гүйцэтгэж байна. Барилгын дотор халаалтын систем угсрах ажил болон дээврийн парпет өргийн ажлууд хийгдэж байна.

Хэрлэн сумын 3 дугаар багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын 1 дүгээр давхрын өргийн ажил хийгдэж дуусан хучилтын ажил эхлэхэд бэлэн болоод байна.

Хэрлэн сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Түүх соёл” ХХК Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

Барилгын суурийн ажил хийгдэж, 30%-ийн гүйцэтгэлтэй ажил явагдаж байна.

Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 640 хүүхдийн суудал бүхий сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэхээр “Шимт газар” ХХК шалгараад байна.

Одоогоор суурийн нүх ухах ажил хийгдсэн суурийн ажлын бэлтгэл байдал хангагдаж, баганан суурийн хэв хашмал угсрах ажил явагдаж байна.

“Сүхжин” ХХК-ийн хийж гүйцэтгэж байгаа Музейн барилгын суурийн ажил хийгдэж байна. Тус барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хамт хяналтын ажлыг гүйцэтгэж байна.

Чулуунхороот сумын спорт заалны барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Гадна фасадны ажил бүрэн дуусаж гадна тохижилт, дотор заслын ажлууд хийгдэж байна. Гүйцэтгэгчээр “Айнекс инженеринг” ХХК ажиллаж байна.

Хэрлэн сумын 4 дүгээр багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг “Стандард резиндэнс констракшн” ХХК хийж гүйцэтгэж байна. Барилгын талбайд гадна дотор ханын өргийн ажил хийгдэж байна.

Халхгол сумын нутаг дэвсгэрт “Бүжнар” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй “Нийтийн орон сууцны барилгын дээврийн засвар /Хэрлэн сумын 6-р багт-2, 7 дугаар багт-3, 9 дүгээр багт-4, 11 дүгээр багт-1, Халхгол суманд-4/ ажлын 10 дугаар багц “Халхгол сумын орон сууцны байрууд /4 байр/” ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан.

Матад сумын нутаг дэвсгэрт “Дорнын ундаргат эрдэнэ” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн өмчийн орон сууц шинээр бий болгох” ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан.

Матад суманд “Хөвсгөл геологи” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй “Соёлын төвийн барилга”-ын барилга угсралтын ажилд техникийн хяналтын ажил хийж гүйцэтгэлээ. Тус “Соёлын төвийн барилга”-ын барилгы угсралтын ажлын үндсэн хийц дууссан, сэндвичэн дээвэр хийгдсэн ба 1 дүгээр давхрын өрлөг өрөгдөж дуусан 2 дугаар давхрын өрлөг 90%-тай явагдаж, ажил зогссон, удааширсан байдалтай байна.



2 дугаар давхрын багана, дамнуруу, хучилтыг үл эвдэх аргаар буву шметын алхаар цохиж бетоны бат бэх тодорхойлсон.

Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт “Дорнод авто зам” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Галын голын гарамын засвар” ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан.

Гурванзагал суманд “ЦОДММ” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй “Соёлын төвийн барилга”-ын барилга угсралтын ажилд техникийн хяналтын ажил хийж гүйцэтгэлээ. Тус соёлын төвийн барилгын барилга угсралтын ажлын үндсэн хийц дуусан 1 болон 2 дугаар давхрын өрлөг өрөгдөж байна. Ажил удааширсан байдалтай байна.

Мөн Гурванзагал суманд “ИГ” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Сургууль болон Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн барилга угсралтын ажилд техникийн хяналтын ажил хийж гүйцэтгэлээ.

Чойбалсан суманд “Дорнын гэрэлт цамхаг” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Дотуур байрны ариун цэврийн байгууламжийн барилга угсралтын ажилд техникийн хяналтын ажил хийж гүйцэтгэлээ. Тус ажлын дотор засал хийгдэж дуусаад гадна талын инженерийн шугам сүлжээний ажил хийгдээгүй үлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай” 2020 оны 144 дүгээр тогтоолоор баталсан. Иймд шинээр баригдаж байгаа барилга болон их засварын ажлын зураг төсвийг боловсруулахдаа дээрх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах талаар зураг төслийн “Талын хас констракшн” ХХК, “ДОЗТ” БГБХНөхөрлөл, “ИГ” ХХК, “Нью бест дизайн” ХХК-иудад албан тоот хүргүүлсэн.

Таван Өргөө Сууц өмчлөгчдийн холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу 21 дүгээр байрны урд авто зогсоолд хурын ус тогтож байгаад үзлэг шалгалт хийж ус зайлуулах суваг бөглөрсөн байсныг гаргуулан усыг зайлуулсан.

Иргэн, аж ахуй нэгжийн ирүүлсэн хүсэлтийн дагуу цэвэр усан хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл олгох ажлын хэсэгт оролцон техникийн нөхцөл олгон ажилласан.



Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу макет хийлгэх ажлын тендер шалгаруулалтад “Тоонто гранд” ХХК шалгаран хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу макет хийх ажлыг бүрэн хийж дуусан аймгийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын .. өдрийн А/365 дугаар захирамжаар байгуулагдсан комиссын бүрэлдэхүүнд ажиллаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн 66,000,000 төгрөгөөр Хүүхдэд ээлтэй орчин” төслийн хүрээнд хөдөөгийн сумын цэцэрлэг, сургуулийг боловсон ариун цэврийн байгууламжтай болгох ажлын 5 дугаар багц буюу /Булган сумын ЕБС-ийн дотуур байр/” ажлыг “Дорнын их өгөөж” ХХК шалгаран гүйцэтгэж байна. Барилгын гадна бохирын ажил бүрэн хийгдэж дууссан. 2 худаг бүхий соруулах худаг суурилуулсан. Дотор ариун цэврийн өрөөний хэвтээ бохирын шугам, цэвэр усны шугамын ажлууд хийгдсэн, ханын шаазан хавтан наах ажил 80 хувьтай явагдаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхошуу боомтын гаалийн лабораторын барилга угсралтын ажилд барилга техникийн хяналт гүйцэтгэн аймгийн Засаг даргын 2020 оны А/360 дугаар захирамжийг үндэслэн 14 хүний бүрэлдэхүүнтэй комисс ажиллан тус барилга байгууламжийг үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээн авлаа.

Мөн аймгийн орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй “Шинэ усан сан-6” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх /Хэрлэн сум/” ажлыг “Баянлуу” ХХК, Ашиглалтгүй болсон янданг буулгах ажлын зардал /Хэрлэн сум 2 дугаар баг/ ажлыг “Жорон” ХХК, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын сантехникийн засвар /Хэрлэн сум, 1 дүгээр сургууль ажлыг “Дорнын их өгөөж” ХХК, Инженерийн шугам сүлжээ засвар /Дорнод аймаг, Хэрлэн сумын 4-р баг багшийн коллежийн 5,6,7-р байр ажлыг “Ган-Октаэдр” ХХК, Ягаанцээнэ өрхийн эмнэлгийн барилгын дотор засвар /Хэрлэн сум ажлыг “Ган-Октаэдр” ХХК, “Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны цонх засварын ажил /Хэрлэн сум 5 дугаар сургууль/” ажлыг “Тал нутгийн Хан хэрлэн” ХХК, Орон сууцны 21 дүгээр байрны урд талд явган хүний зам барих /6-р баг/ ажлыг “Авто-агро” ХХК, Орон сууцны 9, 11 дүгээр байрны дунд явган хүний зам барих /9-р баг/ ажлыг “Авто-агро” ХХК тус тус гүйцэтгэж дууссаныг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2020 оны А/13 тоот тушаалын дагуу байнгын ашиглалтад хүлээн авсан.

Хэрлэн сумын нутаг дэвсгэрт “**Донж Өргөө**” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Орон сууцны 3, 7, 20, 21 дүгээр байрны дээврийн засвар, “**Бүжнар**” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Орон сууцны 29, 30 дугаар байрны дээврийн засвар, “**Дорнод хийц**” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй “9 дүгээр цэцэрлэгийн гадна цэвэр усны шугамын засвар”, “**ЦМК**”

ХХК-ийн хийж гүйцэтгэж буй “Сургууль, цэцэрлэгийн бүс төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх” ажлыг Багц-1, Багц-7 ажлуудад захиалагчийн хяналт гүйцэтгэн ажиллаж байна.

#### БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР:

“Хоггүй цэвэрхэн Монгол” аяныг орон нутгийн хэмжээнд 2019 оны 8 дугаар сараас 2020 оны 6 дугаар сар хүртэл хугацаанд зохион байгууллаа. Аяны хүрээнд 38 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 800 аж ахуй нэгж, байгууллага, 19431 албан хаагч, ажилчин, иргэд хамрагдаж, 1293,5 тонн хог хаягдлыг цэвэрлэж, сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажилд 12683 оюутан, сурагч, албан хаагч, иргэд хамрагдаж, сошиалаар олон нийтэд хүргэсэн хандалтын тоо 30854-д хүрч иргэдийн сэтгэл ханамжийн баталгаа өндөр байна. Аяны тайланг сумдаас авч нэгтгэн БОАЖЯ-ны [info@ecc.gov.mn](mailto:info@ecc.gov.mn) хаягаар хугацаанд хүргүүлж ажилласан. “Үнсээ ил задгай хаяхгүй байцгаая”, “Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагатай хамтран дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ашиглан ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн хийж, үзэсгэлэн гаргаж, олон нийтэд дахин ашиглах боломжтой хогийг хаялгүй ашиглахыг уриалж, сурталчлан таниулах” зэрэг 2019 оны 12 дугаар сар, 2020 оны 4 дүгээр сард зохион байгуулсан ажлаараа БОАЖЯамнаас зарласан уралдаанд Зүүн бүсдээ 2 удаа шалгарч тус бүрт нь 1 сая төгрөгийн урамшуулал авахаар болоод байна.

Химийн бодисын сөрөг нөлөөллийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Хэрлэн сумын 1, 2, 5, 8, 11, 12 дугаар сургууль, Шинэ хөгжил цогцолбор сургууль, Хан-Уул цогцолбор сургууль, Баяндун, Цагаан-овоо, Дашбалбар, Матад, Халхгол, Булган сумын ерөнхий боловсролын сургууль, Боловсрол, соёл урлагийн газарт ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй, нэр хаяг тодорхойгүй 161,7 литр/кг бодисыг аймгийн Засаг даргын 2019 оны А/147 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг химийн хортой болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх холбогдох хууль, журмын дагуу сургуулиудаас 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хураан авах ажлыг зохион байгуулан, Хилийн 0132-р ангийн зэвсгийн агуулахад түр хугацаагаар хадгалаад байна.

Хог хаягдлаа ангилан ялгах, эргүүлэн цуглуулах, дахин боловсруулах ажлыг зохион байгуулах уралдааны удирдамжийг сумдад албан бичгээр хүргүүлэх, байгууллагын вэб сайт, цахим хуудас, төрийн байгууллагуудын болон орон нутгийн фэйсбүүк группүүдээр олон нийтэд сурталчиллаа. БОАЖЯамнаас зарласан болзолт уралдааныг орон нутагт шалгаруулах аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/338 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг Хэрлэн суманд хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Хэрлэн номин бизнес төв”, “Талын Алтан Уул” ХХК-ийн ажилтай газар дээр нь 2 удаа очиж танилцан, үзэж шалган хугацаатай үүрэг чиглэлийг өгч ажиллаа.

- Хэрлэн сумын 2 дугаар багт хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Талын Алтан Уул” ХХК нь аж ахуй нэгж, байгууллага, иргэдээс дахин ашиглах боломжтой хог хаягдлыг цуглуулан авч, эргүүлэн ашиглаж, эдийн засгийн эргэлтэнд

оруулах, ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах зэрэг ажлыг орон нутагтаа хэрэгжүүлж, шинэ санаа санаачлага гарган ажиллаж байгаа нь БОАЖЯамнаас зарласан уралдааны болзлыг хангасан тул холбогдох материалыг бүрдүүлэн БОАЖЯамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар хүргүүлээд байна.

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын баталсан 2020-ХОХБТХ-001 тоот удирдамжийн хүрээнд “Бөмбөө-Уул”ХХК-ийн гүйцэтгэсэн “Эрээнцав” боомтын вагон ариутгах шугамын угсралтын ажлын байдалд нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг захиалагч тал болох “Шинь Шинь”ХХК-ийн төлөөлөгч Н.Гэрэлтуяа, гүйцэтгэгч “Бөмбөө уул”ХХК-ийн инженер Б.Агваанжамц нарыг байлцуулан газар дээр нь ажиллуулж, хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар байнгын ашиглах цахилгааны болон усны шугам холбогдоогүй, ариутгалын шингэн бодис хадгалах савны багтаамж /1,2тн/ бага, нөөцийн сав байрлуулаагүй, ариутгалын бодис цацах хошуу хоорондын зай хол байрласан, ариутгагч байрлах барилгад вагоны ариутгалыг хянах цонх угсраагүй, ажиллах орчинг бүрдүүлээгүй зэрэг зөрчил, дутагдал илэрсэн тул одоогийн байдлаар тус ариутгалын пунктыг ашиглах боломжгүй учраас хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажиллаа.

- Хэрлэн суманд “Мод, модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэх”, “Шатахуун түгээх станц барих”, Булган суманд “Фермерийн аж ахуй эрхлэх” зэрэг төслүүдэд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргалаа.

**Уул уурхайн хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дараах ажлыг зохион байгууллаа.**

Тус аймгийн нутагт уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд 2020 онд явуулахаар хууль тогтоомжид заасан баримт бичгийн

бүрдэлийг хангасан нийт 7 аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний батлагдсан хувийг татан авч, албан ажилдаа ашиглаж байна. Үүнд: “Дун уянга”, “Дорнын хүдэр”, “Нью нимон майнинг”, “Зэст өндөр”, “Шинь шинь”, “Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн гэрээт 19, 21 дүгээр талбай тус тус байна.

Баримт бичгийн бүрдлийг ханган ажиллаж байгаа уул уурхайн аж ахуйн нэгжийн захирал, байгаль орчин хариуцсан ажилтан нарт салбарын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаа.

Мөн аймгийн Засаг дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хамтран түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Сүхжин”, “ДОЦ” ХХК-ийн ашиглалтын талбайд хяналт хийх ажилд оролцсон.

- Дорнод аймгийн Засаг даргын баталсан БОХНСЗ-2.1.2/2020 тоот удирдамжийн хүрээнд Багц-4 буюу Дашбалбар сумын “Шандын булаг”-ийн эхийг хашиж хамгаалах ажил, мөн Багц-3 буюу Баянтүмэн сумын “Сүүл нуурын булаг”-ийн эхийг хашиж хамгаалах ажлуудыг актын дагуу хүлээн аваад байна.
- 2 аж ахуйн нэгж, Булган, Матад, Хэрлэн сумдын 14 иргэн нийт 16 худгийн цооног өрөмдөх зөвшөөрөл гаргасан.
- Чойбалсан хотын нийтийн эзэмшлийн 61.2 га талбайд ногоон байгууламжийн хортонтой тэмцэх ажилд ойн хортон шавьжтай тэмцэх тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага “Залуу төгөл”ХХК шалгарч гэрээ байгуулсан бөгөөд графикт төлөвлөгөөний дагуу 4-р сарын 30-наас 5-р сарын 4-ний хооронд өндгөн үе шатанд байгаа хайлаасны урын бөөсийг судлан, судалгааны дүнд үндэслэн 5-р сарын 18-наас 20-ны өдрүүдэд 3 хоногийн турш аймгийн нийтийн эзэмшлийн 17 байршилд шингэн бэлдэц хор шүршиж устгалын 1-р үе шатны ажил бүрэн хийгдээд байна. Амьд өндөг хайлаас модонд маш ихээр байсан бөгөөд, эвцэлдэх үеэр 7-р сард дахин судалгаа хийж, 8 сарын эхээр 2-р үе шатны устгал хийгдэх юм.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй БОХНСЗ-2.2.4/2020 дугаартай “Нийтийн эзэмшлийн талбайн хөрсийг элэгдлээс хамгаалах зорилгоор ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлнэ” гэрээт ажлын гүйцэтгэгч “Ар Өвөр Эрээн”ХХК-ийн Чойбалсан хотын ногоон байгуулаж нэмэгдүүлэх боломжтой нийтийн эзэмшлийн талбайн болон орон сууцны гадна хайсжуулалтын ажлын явцад хяналт тавьж, газрын давхцал маргааныг газар дээр нь шийдвэрлэн, СӨХ-ны дарга нартай уулзаж ажлын зорилгыг танилцуулж ажиллалаа.
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Канад улсын MERIT төслийн санхүүжилтээр Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газраас хэрэгжүүлсэн

“Хөгжлийн стратеги, бодлого боловсруулалтын мэргэжилтнүүдийг чадавхижуулах богино хугацааны модульт сургалт”-нд мэргэжилтэн Т.Уянгоо хамрагдаж төлөвлөгөө боловсруулахад орон нутгийн нөөц боломжийг эдийн засгийн үр ашигтай зөв төлөвлөх, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явцтай уялдуулах талаар мэдлэг ойлголттой боллоо.

## **Зургаа: НИЙГМИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР**

### **НЭГ: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ**

#### **БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР**

Аймгийн Онцгой комиссын 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 38 дугаар хуралдаанаар бусад аймаг, нийслэлийн гаргасан шийдвэрийг харгалзан, иргэдэд биеийн идэвхитэй хөдөлгөөнөөр дархлаагаа дэмжих боломжийг олгож спорт заалыг нээн үйл ажиллагааг 10:00-22:00 цаг хүртэл явуулахаар шийдвэрлэв.

Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн корона вируст халдвар Covid-19 цар аюулт цар тахлын хөл хориотой үед хүүхэд, залуусыг хөлбөмбөгийн спортоор хичээллэж, дархлаагаа дэмжих зорилгоор “Цахим жонглёр”-ын тэмцээнийг 4 насны ангиллаар зохион байгуулж, 30 гаруй бичлэг тавигдан 3000 гаруй хүмүүсийн хандалтыг авсан.

Монголын Үндэсний Бөхийн холбооноос аймгийн Баяр наадмын бөхийн барилдааныг зохион байгуулах салбар хорооны жаяг, дэгийн багт ажиллах гарын даа нарт цахим сургалтыг зохион байгуулав. Уг сургалтад аймгаас 9 хүн хамрагдав. Мөн түүнчлэн аймгийн Баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 128 бөхчүүдийг барилдах чиглэл ирсний дагуу 6 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 28-ны өдрүүдэд цахим хуудсаар дамжуулан бүртгэлжүүлэв.

#### **ХОЁР. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР**

Олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа:

Ерөнхий боловсролын 17 сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын дунд “Их сорилго 2020”-ыг 10 судлагдахуунаар онлайнаар зохион байгуулж, давхардсан тоогоор 1860 сурагч хамрагдсан. “Их сорилго 2020” шалгалтын мөрөөр 10 судлагдахуунаар мэргэжилтнүүд зөвлөмж боловсруулан, “Дорнод ЭЕШ 2020” группээр лайв хийсэн.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах 2 сургууль, шалгалт авах 49 танхим, зохион байгуулагч 32, хянагч багш 50, үйлчилгээний ажилтан 12, эмч 2 ажиллахаар бэлтгэлийг хангаж, хяналт тавьсан.

Орон нутгийн телевизээр 2 удаа Элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотой мэдээллийг иргэдэд хүргэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, 12 дугаар ангийн багш нартай онлайн уулзалтыг 2 удаа зохион байгуулсан.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот болон Дорнод аймгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй оюутан солилцооны хөтөлбөрийн дагуу 2020 онд Хөлөнбуйр дээд сургуулийн Хятад хэлний бэлтгэл ангид 1-2 жил хүртэлх хугацаанд Дорнод аймгийн иргэдийг сургах мэдээллийг иргэдэд хүргэн бүртгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон цахим сүлжээгээр хүргүүлсэн.

## **ГУРАВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**

“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:

Хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 6 дуудлагыг хүлээн авч хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан бөгөөд шийдвэрлэлт 70 хувьтай байгаа бөгөөд “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө” энэ сард нийт 10 хүүхэд, иргэн давтамжтай зөвлөгөө үйлчилгээ авсан. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д энэ сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 10 насанд хүрэгч, 2 хүүхдийг хүлээн авч, 2-30 хоногийн хугацаатай байршуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлэн харьяа хамтарсан багт шилжүүлж, үйлчлүүлэгчтэй ажиллах кейс төлөвлөгөө боловсруулан хариу үйлчилгээ үзүүлж байна. Гэр бүлийн маргаан, үл ойлголцолтой 2 гэр бүлд хосын зөвлөгөө, сэтгэл зүйн оношилгоо, сэтгэлзүйн хямралтай 3 эмэгтэйд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, 1 хүнд ганцаарчилсан сургалт зохион байгуулав. Үрчлэлтийн дүгнэлт хийгдэхээр ирүүлсэн 2 өрхийн нөхцөл байдлыг судлан дүгнэлтийг гарган Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Мөн насанд хүрээгүй хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр 2 шүүх хуралд оролцож, мөрдөн байцаалтын шатанд 2 удаа тус тус оролцож хүүхдийн эрхийг хамгаалан ажиллаж байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн коронавирус Covid 19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриатайгаар зохион байгуулсан.

Орон нутгийн “Гэр бүл хөгжил дэвшил хөтөлбөр”-т хамрагдаж буй 14 сумын 231 зорилтот өрхийн 642 хүүхдэд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлөөс витаминь багц бүхий гарын бэлгийг гардуулахаас гадна 06 дугаар сарын 01-ний өдөр мэндэлсэн 6 хүүхдэд нярайн багц гардуулж, хүндэтгэл үзүүлэв. Мөн эх үрсийн баярын үйл ажиллагаатай уялдуулан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 19 дүгээр талбайн хамт олонтой хамтран Хэрлэн сумын 2 дугаар багийн 1 өрхөд иж бүрэн 5 ханатай гэр, хашаа, газар, цахилгааны асуудлыг бүрэн шийдвэрлэж, гэр бүлдээ тав тухтай амьдрах боломж, нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийн хүрээнд хүүхдийн хөдөлмөрийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын болон нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх зорилгоор илрүүлгийн ажлыг зохион байгуулж, томоохон худалдааны төвүүд, авто засвар, машин угаалгын газар, сүм хийд, гандан, саун массажны газар, барилга байгууламж зэрэг нийт 25 газрыг хамруулж, тухай бүрт нь зөвлөмж өгч эрсдэлийн тодорхойлж ажилласан.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газар, Онцгой байдлын газартай хамтран “Усны ослоос урьдчилан сэргийлье” арга хэмжээг эхлүүлж, голын эрэг дагуу хараа хяналтгүй хүүхдэд хяналт тавин ажиллаж байна. Мөн аялал, амралт, зугаалгын цаг эхэлсэнтэй холбогдуулан гол усны аюулаас урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдэд тавих хараа, хяналтаа сайжруулах, голын эрэг дагуу хүүхдийг явуулахгүй, тоглуулахгүй байх, тээврийн хэрэгслийн жолооч нар баталгаатай зам, гүүрээр зорчиж гол усанд унах, осолдох эрсдлээс урьдчилан сэргийлэхийг мэдээллийг тогтмол хүргэж байна.

Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:

Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт”-ыг цувралаар өсвөр үе, залуучууддаа тогтмол зохион байгуулж байна. Тайлант сард аж ахуй үйлчилгээнд ажиллаж, хорих ял эдэлж байгаа, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүд, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны баривчлах байранд хүмүүжиж байгаа нийт 215 иргэд, хүүхдэд “Жендэрийн тухай ойлголт”, “Харилцаа хандлага”, “Өөртөө итгэх итгэл”, “Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах”, “Стрессийг

зохицуулах нь” “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” “Холбоо тогтоох чадвар” сэдвүүдээр сургалтыг зохион байгуулав.

Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 5 залуучуудад “Хүрч очих үйлчилгээ”-г үзүүлж, амьдрах ухааны чадвар олгох, хувь хүний хөгжлийг дэмжих цуврал сургалтыг хүргэн ажилласан.

“Анна хоме” асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхдүүдийн амралт, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор тус газрын залуучуудын хөгжлийн албанаас төлөвлөгөө гарган үе шаттай сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж байна. Үйл ажиллагааг тэдний эрэлт хэрэгцээнд үндэслэн амьдрах ухааны ур чадвар олгох сургалт, хөгжөөнт тэмцээн, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө зэрэг үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

## **ДӨРӨВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ**

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС**

1. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын санд 2020 оны 06 дугаар сард 1396866,9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2982506,39 мянган төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 117,04 хувиар биелүүлсэн байна. 2020 оны 06 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Нийгмийг даатгалыг сангийн орлого /мянган төгрөг/

д/д	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	742322.6	1855600.0	114,23
2	Тэтгэмжийн даатгалын санд	77992.6	206807.32	127,46
3	ҮОМШӨ-ний даатгалын санд	58945.4	229688.72	155,11
4	Ажилгүйдлийн даатгалын санд	13240.8	51054.4	159,05
5	ЭМД-ын сан	504365.5	639355.95	110,25
	Нийт	1396866.9	2982506.39	117,04



2020 оны 06 дугаар сард нийт 216 ажил олгогч байгууллагын 4755 даатгуулагчийн 192883,5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс(ЭМД-ын шимтгэлээс бусад) чөлөөлсөн.

Түүнчлэн 3890 сайн дурын даатгуулагчдын 649702,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс тус тус чөлөөлсөн байна.

## 2. Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 06 дугаар сард шинээр нийт 124 иргэнд тэтгэвэр тогтоосон. Үүнээс:

Өндөр насны тэтгэвэр 99, (малчин 26, хувь тэнцсэн 7, хүүхдээр 16, хүнд нөхцлөөр 4, хортой нөхцлөөр 1, цэргийн алба хаасны тэтгэвэр 3, хэвийн өндөр настан 58)

Тахир дутуугийн тэтгэвэр 21,

Тэжээгч алдсны тэтгэвэр 4 тус тус тогтоосон.

Түүнчлэн 2020 оны 06 дугаар сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас нийтдээ:

Өндөр настан 8900,

Тахир дутуу 2765,

Тэжээгчээ алдсан 610,

Цэргийн тэтгэвэр 599 нийт 12874 тэтгэвэр авагчдад нийт 4996284,03 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон.

## 3. Тэтгэмж олголтын талаар:

Тэтгэмжийн даатгалын сангаас

Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 161,

Жирэмсэн, амаржсны тэтгэмж 110,

Оршуулгын тэтгэмж 38 даатгуулагчид нийтдээ 300935,6 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон.

## 4. Ажилгүйдлийн тэтгэмж олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 6 дугаар сард нийт 81 даатгуулагчдад 40,8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгов. Энэ нь өмнөх сартай харьцуулахад 6 даатгуулагчийн 5,0 сая төгрөгөөр ажилгүйдлийн даатгалын зардал буурсан үзүүлэлттэй байна.

5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал:

Уг сангаас нийтдээ 94 тэтгэвэр авагчдад нийтдээ 140526,7 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Рашаан сувиллын зардал 1 даатгуулагчид 332,0 мянган төгрөгийг олгосон.

6. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:

2020 оны 06 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 647072.2 мянган төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 82,1 хувь буюу 530891.9 мянган төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага, 17,9 хувь буюу 116180.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна. Нийт авлагын 39.8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

7. Ажилгүйдлийн даатгалын сангаас ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх талаар:

Цар тахлын улмаас орлого нь 50 буюу түүнээс дээш хувиар буурсан ажил олгогч байгууллагад ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотойгоор ажилгүйдлийн даатгалын сангаас 37 ажил олгогч байгууллагын 456 даатгуулагчид 44400,0 мянга төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.

8.Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын мэдээлэл:

Дэлхий нийтийг хамарсан цар тахал шинэ коронавируст халдвар (COVID-19) гарсантай холбогдуулан иргэдийг олноор цуглуулахгүй байх шийдвэр гарсантай холбогдуулан Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс цахим хурлаар 4 удаа хуралдаж, 281 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 40 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 190 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 51 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Цуцлагдсан 40 иргэний 25 нь өндөр насны тэтгэвэр тогтоолсон, 9 нь заалтын хугацаа дууссан, 6 нь эмчлэн эрүүлжсэн иргэд байна.

## **ТАВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ:

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, ажилгүйдэлд өртөж болзошгүй, их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгссөн 76 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгснөөс хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөөг 49 иргэн, хөдөлмөр эрхлэлтийн талаар 26 иргэн, зөвлөгөө өгөөд байна. Зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан иргэдийг насны ангиллаар авч үзвэл 15-24 насны 14 иргэн, 25-34 насны 20 иргэн, 35-44 насны 21 иргэн, 45-54 насны 19 иргэн, 60-аас дээш насны 2 иргэн тус тус хамрагдсан байна.

Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэний мэдээ:

Энэ сард 14 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 226 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу Дорнод ажлын байр фэйж хуудас болон хэвлэмэл хуудсаар иргэдэд санал болгож, 211 иргэнийг ажлын байранд зуучлаад байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах хамтран ажиллах гэрээний дагуу “Шинь Шинь” ХХК-ийн нээлттэй ажлын байранд 47 иргэнийг ажлын ярилцлаганд орж, 11 иргэн байнгын ажлын байраар хангагдаад байна.

Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:

Энэ сард 1758 ажил хайгч иргэн, үүнээс 792 эмэгтэй бүртгэлтэй байна. Үүнээс 50 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 23 хувийг тусгай, техникийн боловсролтой иргэд, 20 хувийг дээд боловсролтой иргэд, 7 хувийг суурь боловсролтой иргэд тус тус эзэлж байна.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалт:

“Дорнод аймгийн Оёдолчдын холбоо”, Политехник коллеж хамтран оёдолчдын мэргэжлийн давтан сургалтад нийт 55 иргэнийг хамруулахаар төлөвлөсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 50 хувийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 100 гаруй иргэнээс төсөл ирснээс 30 иргэнтэй гэрээ байгуулж 59,500 мянган төгрөг зарцуулсан. Ажлын хэсгийн шалгаруулалтад тэнцсэн 2 иргэн гэрээ байгуулаагүй хүлээгдэж байна.

Орон нутгийн үйлдвэрлэгчийн борлуулалтын дэмжих зорилгоор “Ольхон” ХХК-ийн 4 дэлгүүрт борлуулалтын цэгийг бий болгож 3600,0 мянган төгрөгийг зарцуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны түрээсийн хөнгөлөлт: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнд 2,073.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж байна.

Аж ахуй эрхлэлтийн сургалт:

Орон нутгийн эрх бүхий “Дорнод талын хөгжлийн хөтөч” сургалтын байгууллагатай хамтран маркетинг ба борлуулалт, төсөл боловсруулах, бүлгийн сургалт, бизнэсээ эхэл зэрэг сургалтуудыг зохион байгуулж, 30 иргэнийг хамруулан 900,0 мянган төгрөг зарцуулаад байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөр:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны А/22 дугаар тушаалаар “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдсан. Хэрлэн сумын хэмжээнд хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 102 иргэний төсөл хүлээн авч, ажлын хэсэг төсөл ирүүлсэн иргэдийн үйл ажиллагаанд нөхцөл байдлын үнэлгээ, бичиг баримтны бүрдэл шалгаж үе шаттай сонгон шалгаруулан 21 иргэний төслийг сонгон шалгаруулж, 105,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн гэрээ байгуулан санхүүжилтийг олгоод байна.

“Дорнод талын хөгжлийн хөтөч” сургалтын байгууллагатай хамтран төсөл боловсруулах, “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл, зэрэг аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж, 66 иргэнийг хамруулан 1,980.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах зэрэг ажилд Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангаж, орлогыг дэмжих зорилгоор 3 сумын 66 иргэнийг хамруулан 18,172.0 мянган төгрөгийг зарцуулаад байна.

Ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлж, ажлын байртай болгох зорилгоор “Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих” арга хэмжээнд 5 иргэнийг хамруулж 4,060.0 мянган төгрөгийг зарцуулаад байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр:

Ахмад зөвлөх үйлчилгээ:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээнд эрүүл мэндийн салбарт 20 иргэн, хөдөө аж ахуй 1, төрийн захиргаа 6, боловсролын салбарт 5, нийт 32 ахмадад 9,324 мянган төгрөг зарцуулаад байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр

Төсөл, хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ольхон” ХХК-ийн сүлжээ дэлгүүрүүдэд 4 борлуулалтын цэгийг байгуулан 3600,0 мянган төгрөгийг зарцуулаад байна. Мөн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж буй 3 иргэнд 3200,0 мянган төгрөгийн дэмжлэгт хамруулсан.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих” хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 24 залуучуудад төсөл болосруулах, маркетинг ба борлуулалтын сургалтуудыг зохион байгуулан “Дорнод талын хөгжлийн хөтөч” ТББ-тай хамтран ажиллаж байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийн үйлчилгээг Төрийн банкаар дамжуулан олгохоор ажиллаж байна.

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийн үйлчилгээнд хамрагдсан 9 иргэнд зээлийн дараах санхүүгийн сургалтад хамруулан 535.5 мянган төгрөгийг зарцуулсан. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн орон нутгийн санаачлагын төсөлд 618.7 мянган төгрөгийн зарцуулаад байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр 1805 иргэн хамрагдаж 493.7 сая төгрөг, асаргааны тэтгэмжид 13420 иргэнд 120.7 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 251 иргэнд 68.6 сая төгрөг, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжид 5210 иргэнд 348.9 сая төгрөг, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлтөд 253 иргэнд 45.6 сая төгрөг, алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлтийг 28 ахмад настанд 4.3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийг 251 иргэнд 10.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөний талаар:

Тус сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2325 өрхийн 6926 томхун, 6076 хүүхдэд нийт 13002 хүнд хүргэж 1,274,440.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд 32 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч бүртгэн ажиллалаа. Үүнээс өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд

хамрагдахыг хүссэн 18 өргөдөл, амьжиргааны түвшингийн тодорхойлолт авахыг хүссэн 12 өргөдөл байна.

Халдварт короновирус /КОВИД-19/ өвчний дэгдэлттэй холбогдуулан улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэний улмаас Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны өрхөөр зочлох үйл явцыг бэлэн байдлын үед хориглосон. Шийдвэрлэгдээгүй байгаа өрхийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн насанд хүрсэн гишүүнтэй эргэн холбогдон өрх дэх 0-18 насны хүүхдийн хүүхдийн төрсний гэрчилгээг хуулбарлан авч мэдээллийн сангийн “Хүүхдийн мөнгө” цэсэнд бүртгэн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгож байна.

Амьжиргааны түвшний 409,679 босго шугамаас доогуурт багтсан 18 иргэнд тодорхойлолт олгож, шинээр төрсөн 173 хүүхдийн мэдээллийг төрсний гэрчилгээний хуулбарыг үндэслэн өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсанаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Аз жаргалын бэлэг” сэдэвт аян өрнүүлж хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдэд гарын бэлэг өгч, эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан.

Харааны бэрхшээлтэй 6 иргэнд Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооноос мэргэжлийн багш урьж оролцуулан Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны Дорнод аймаг дахь салбартай хамтран 40 цагийн брайль үсгийн анхан шатны сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна.

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Дорнод аймаг дахь зөвлөлийн дарга болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбооны Дорнод аймаг дахь салбарын гишүүдтэй хамтран төр болон хувийн хэвшлийн 11 байгууллагын орчны хүртээмж, 4 газрын орон сууцны гадна орчинд тавигдсан явган хүний замын стандартад орж орчны хүртээмжийн байдалд хяналт үнэлгээ хийж, зөрчил арилгуулах зөвлөмж хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/161 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүргүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хэрлэн сумын ерөнхий боловсролын 2 сургууль зэрэг байгууллагууд гадна налуу шатыг засаж сайжруулсан байна. Нэвтрүүлэг хийж орон нутгийн телевизүүдээр иргэдэд хүргэн ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулиуд нэмэлт өөрчлөлт оруулах талаар иргэд болон төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн хүргүүлсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ:

Бүлгийн төсөл:

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор 7 бүлгийн төслийн явцтай газар дээх нь очиж танилцаж, нөхцөл байдлыг дүгнэн 4 бүлгийн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлж 4,0 сая төгрөгийг зарцуулсан.

Үүнд: Зорилтот бүлгээр авч үзвэл: Аж ахуйн нэгж 3, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 4, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх 1, нийт 8 иргэн.

Бүлгийн төслийг үйл ажиллагааны чиглэлээр харуулбал:

Ногоо, жимс жимсгэнэ 2 бүлэг 2,0 сая төгрөг,

Үйлчилгээ /бусад/ 2 бүлэгт 2,0 сая төгрөг,

Хөгжлийн Бэрхшээлтэй хүүхдүүдийн бие бялдарын хөгжил, дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор тохируулгат дасгал, спорт тоглоомоор долоо хоногт 2 удаа спорт зааланд хичээллэж байна.

## **ЗУРГАА. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ**

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

“Дэлхийн тамхигүй өдөр” аяны 7 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан 13 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн. Сумдын Засаг даргын Тамгын газарт Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 1/464 дугаар албан тоотоор тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах чиглэлээр албан бичиг хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 5 такси үйлчилгээ явуулдаг газруудын 44 жолоочид 2 төрлийн 70 гаруй сурталчилгааны материал тараан ил задгай тамхины ишээ хаяхгүй байхыг зөвлөсөн.

Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор ЭМЯ, НЭМҮТ, НҮБ-ын Хүүхдийн сангаас санаачлан 5 сарын 1-ны өдрөөс 9 сарын 1 хүртэл “Эрүүл ахуйн аян” зохион байгуулан ажиллаж байна. Аяны хүрээнд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган өрх, сумын эрүүл мэндийн төвд хүргүүлсэн.

Тархвар судлалын заалтаар аймгийн хэмжээнд тарваган тахлын дархлаажуулалтанд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум өрхийн нийт 451 иргэн хамрагдаад байна.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын тасагтай хамтран хөнгөлттэй эмээр үйлчилгээ үзүүлэх эрх бүхий сумын 13 эргэлтийн эмийн сан, хувийн хэвшлийн 12 эмийн санд гэрээ дүгнэж ажилласан.

Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэгч эмийн сан, эрүүл мэндийн төв шалгаруулах болзолт уралдааныг зарлан, удирдамжийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.

Эмийн жорын маягт жор бичилтийн стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор “Зөрчилгүй жор бичигт эмч” шалгаруулах болзолт уралдааныг зарлан удирдамжийг хүргүүлсэн.



